

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН  
ЗАХИРАЛ Н.ЗОРИГТБААТАР  
ТАНАА

2020.02.21 № 06/620  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Байгалийн түүхийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгалийн түүхийн музейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Н.Зоригтбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгө болон зардлын дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэх 2 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “СМД аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Байгалийн түүхийн музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх улмаар Ази тивдээ тэргүүлэх зэргийн байгалийн түүхийн музей болоход оршино.

Байгалийн түүхийн музейн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус музейн одоо мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Байгалийн түүхийн музей нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acoulous” программ хангамж ашигладаг байна.

Байгалийн түүхийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Байгалийн түүхийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 412,371.5 мянган төгрөгөөс тооцон 8,247.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Үлэг гүрвэлийн төв музейг нэгтгэсэнтэй холбоотойгоор 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,846,515.1 мянган төгрөг байсан ба үүний 965,309.3 мянган төгрөг нь үйл ажиллагааны бус зардал буюу музейн барилгыг нураасантай холбоотойгоор үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз бөгөөд байнгын шинж чанартай биш гэж үзсэн тул нийт зардлаас үйл ажиллагааны бус зардлыг хасаж, гүйцэтгэлийн үе шатанд зөвхөн үйл ажиллагааны зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд эрсдэл бага тул материаллаг байдлыг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 881,205.8 мянган төгрөгийн 2 хувь буюу 17,624.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Байгалийн түүхийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,289,433.0 мянган төгрөгөөр буюу 305.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данснуудад материаллаг өөрчлөлт гарсан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	7,596.9	7,596.9
Бараа материал	35,408.3	157,427.4	122,019.1
Үндсэн хөрөнгө	1,695,561.0	6,855,378.1	5,159,817.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,730,969.3</b>	<b>7,020,402.3</b>	<b>5,289,433.0</b>
Өр төлбөр	-	3,545.7	3,545.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,730,969.3	7,016,856.6	5,285,887.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,730,969.3</b>	<b>7,020,402.3</b>	<b>5,289,433.0</b>

Авлага дансны үлдэгдэл нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 76.8 мянган төгрөг, Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага 10.0 мянган төгрөг, ашиглалттай холбоотой 7,235.0 мянган төгрөг, хувь хүнээс авах 275.0 мянган төгрөгийн авлага юм. Эдгээр нь 2019 онд үүссэн богино хугацаанд барагдах боломжтой авлага байна.

Бараа материал, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хоёр музейг нэгтгэн зохион байгуулснаар үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2019 оны 12 дугаар сарын 17-ны ТӨБЗГ-ын 621 тоот тогтоолоор Үлэг гүрвэлийн төв музейгээс шилжүүлж авсан 130,223.2 мянган төгрөгийн бараа материал орсон ба үүнд үндсэн хөрөнгийн шинжтэй 14,393.5 мянган

төгрөгийн бараа материал байна. Энэ нь Үлэг гүрвэлийн төв музейн бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг буруу бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,619,081.5 мянган төгрөгөөр өссөн. Тайлант онд Үлэг гүрвэлийн төв музейн 6,461,625.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 209,283.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан. Тайлант онд 7,452.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хайгуулаар цуглуулагдсан 7,202.0 мянган төгрөгийн цуглуулгаар музейн үзмэрээ баяжуулсан. ТӨБЗГ-ын 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 365 дугаар тогтоол, 2019 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 639 тоот тогтоолоор Байгалийн түүхийн музейн А, Б блок барилгыг нураасантай холбоотойгоор нийт 2,857,198.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 1,891,889.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгө акталсан байна.

Үлэг гүрвэлийн төв музейгээс 161,264.6 мянган төгрөгийн биет бус хөрөнгө шилжүүлэн авсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,545.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 317.5 мянган төгрөг нь ажилчидтай холбоотой өглөг, 3,228.3 мянган төгрөг нь байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,016,856.6 мянган төгрөг болсон нь тайлант оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн 5,285,887.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Мөн дахин үнэлгээ хийгдсэн үндсэн хөрөнгө акталсантай холбоотойгоор хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 633,541.1 мянган төгрөгөөр буурсныг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга буюу өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн дансанд бичилт хийсэн байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлагийн хөтөлбөрт зориулан 616,442.6 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд 616,442.6 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 571,004.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. 19,843.4 мянган төгрөг нь Үлэг гүрвэлийн төв музейгээс хаалтын балансаар төрийн сангийн үндсэн харилцах дансны үлдэгдэл ба тайлант хугацаанд үйл ажиллагаанд зарцуулагдсан тул төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжсэнээр тайлагнасан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 590,847.9 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь хүүхэд асрах хуулийн чөлөөтэй байгаа ажилтнуудын цалингийн сангийн хэмнэлттэй холбоотой байна.

### **Нэмэлт төсөв:**

Дээд шатны төсвийн захирагчаас 17,801.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 88,339.8 мянган төгрөг, нийт 106,140.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 94,214.9 мянга, урсгал шилжүүлгийн зардалд 3,900.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8,025.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 15,758.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталсан 280, 281 дүгээр тогтоолын хүрээнд одоогийн Байгалийн түүхийн музейн барилгыг нурааж энэ суурин дээр Чингис хааны музей байгуулах, харин Байгалийн түүхийн музейг Их тэнгэрийн аманд шинээр барихаар болсон. Тайлант онд зөвхөн барилга, түүнтэй хамаатай хөрөнгүүдийг акталсан ба хуучин газрын гэрчилгээ Байгалийн түүхийн музейн эзэмшилд хэвээр байгаа. Нөгөө талдаа Их тэнгэрийн аманд өгнө гэсэн газрын гэрчилгээ одоогоор байхгүй байна. Дараагийн аудитаар шинээр баригдах музейн барилгын газрын гэрчилгээг Байгалийн түүхийн музейн эзэмшилд гарсан эсэх, хуучин газрын гэрчилгээ нь Чингисийн музей рүү шилжсэн эсэхийг анхааралдаа авч үзэх шаардлагатай.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Байгалийн түүхийн музей нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 132 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 15,758.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 17,624.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Байгалийн түүхийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Ялтсан бойлер, сейф гэх мэт илт үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бараа материал дээр бүртгэсэн байна.

Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө стандартын 13 дугаар заалттай нийцэхгүй, Байгалийн түүхийн музейн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг дэх 3.1.4 Бараа, 3.1.6 Үндсэн хөрөнгө бүлэгт тодорхойлсон тодорхойлолт, болон санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Ижил төрлийн хөрөнгө өөр өөр ангилалд бүртгэсэн байх, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл аваагүй худалдан авсан үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн байх эрсдэлтэй.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалд бүртгэх

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Үлэг гүрвэлийн төв музейн хөрөнгийг хаалтын баланс гаргасны дагуу 2019.08.29-2019.09.09-ний хооронд тооллого хийсэн бөгөөд, ТӨБЗГ-ын 2019.12.17-ны 621 тоот тогтоолоор балансаас баланст шилжүүлэн авсан байна. Байгалийн түүхийн музейн нягтлан бодогч 2019 онд амжаагүй, 2020 онд зөвшөөрөл авч бараа материалын данснаас үндсэн хөрөнгө рүү бүртгэхээр төлөвлөсөн гэж тайлбар өгсөн.

### 3.2 Зардлын данстай холбоотой асуудал

#### 3.2.1. Илрүүлэлт:

Хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 350.0 мянган төгрөгөөс, 35.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаад, 84.0 мянган төгрөгийн НДШ тооцоогүй байна. Ажилчдад олгосон 3,900.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс 936.0 мянган төгрөгийн НДШ, 345.1 мянган төгрөгийн ХХОАТ тооцоогүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.4 дэх заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн, зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.2.2. Эрсдэл:

Нийгмийн даатгал, татварын байгууллагын хяналт шалгалтаар акт, торгууль тавигдах эрсдэлтэй.

#### 3.2.3. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.4 дэх заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

#### 3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна. Хойшид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>1</u>	<u>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</u>	35,408,310.05	165,024,241.85
33	АВЛАГА	-	7,596,880.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	76,800.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	275,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	10,056.00
335	Бусад авлага	-	7,235,024.45
3351	Байгууллагаас авах авлага	-	7,235,024.45
35	БАРАА МАТЕРИАЛ	35,408,310.05	157,427,361.40
351	Түүхий эд материал	-	69,451,091.00
35110	Тусгай зориулалттай материал	-	69,451,091.00
354	Хангамжийн материал	35,408,310.05	87,976,270.40
35410	Бичиг хэргийн материал	10,296,300.00	18,893,708.00
35420	Аж ахуйн материал	25,112,010.05	27,991,380.90
35450	Барилгын засварын материал	-	2,155,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	38,936,181.50
<u>2</u>	<u>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</u>	1,695,561,036.90	6,855,378,056.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,695,561,036.90	6,855,378,056.82
392	Биет хөрөнгө	1,589,775,576.90	6,597,018,036.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,735,880,713.32	5,348,717,332.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,783,604,118.57)	(78,002,127.77)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,566,333.00	98,566,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,661,751.26)	(97,146,332.76)
39205	Машин тоног төхөөрөмж -компьютер	546,187,817.32	546,252,932.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(423,944,072.35)	(519,760,476.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	251,116,632.00	299,012,476.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(174,909,641.50)	(219,055,754.59)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	407,936,729.00	1,213,965,729.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,788,140.00	6,778,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,049,130.06)	(6,778,500.00)
39217	Ном	4,467,926.00	4,467,926.00
393	Биет бус хөрөнгө	105,785,460.00	258,360,020.00
39301	Програм хангамж	462,000.00	1,452,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(462,000.00)	(1,452,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	105,785,460.00	266,060,020.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,700,000.00)
<u>3</u>	<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</u>	1,730,969,346.95	7,020,402,298.67
<u>4</u>	<u>НИЙТ ӨР ТӨЛБӨР</u>	-	3,545,738.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,545,738.00
413	Өглөг	-	3,545,738.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	317,478.00
4136	Бусад өглөг	-	3,228,260.00

Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,228,260.00
<u>5</u>	<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</u>	1,730,969,346.95	7,016,856,560.67
51	Засгийн газрын хувь оролцоо	1,730,969,346.95	7,016,856,560.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,386,169,214.15	1,386,169,214.15
51101	Өмч:- төрийн	1,386,169,214.15	1,386,169,214.15
512	Хуримтлагдсан үр дүн	(841,866,295.38)	5,077,561,969.32
51210	Өмнөх үеийн үр дүн	(841,866,295.38)	(208,325,244.40)
51220	Тайлант үеийн үр дүн	-	5,285,887,213.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,186,666,428.18	553,125,377.20
<u>6</u>	<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</u>	1,730,969,346.95	7,020,402,298.67

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<u>1</u>	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН -I</u>	352,016,775.00	7,132,402,305.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,992,275.00	6,409,610,415.07
120	Нийтлэг татварын бус орлого	20,992,275.00	6,409,610,415.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,877,575.00	6,409,610,415.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	19,843,443.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,885.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,833,690.00	6,389,766,971.44
120009	Бусад орлого	114,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,024,500.00	722,791,890.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	324,724,500.00	616,442,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	324,724,500.00	616,442,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,300,000.00	106,349,290.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,300,000.00	17,801,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	88,548,290.00
<u>2</u>	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</u>	412,374,981.93	881,205,805.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,374,981.93	881,205,805.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,607,983.11	819,564,090.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,683,245.16	423,153,464.89
210101	Үндсэн цалин	205,120,145.16	322,952,977.89
210102	Нэмэгдэл	-	55,682,615.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,829,000.00	26,529,000.00
210104	Урамшуулал	734,100.00	17,988,872.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,308,566.39	55,788,190.00
210201	Тэтгэврийн даатгал	17,526,733.21	30,724,914.38
210202	Тэтгэмжийн даатгал	2,159,466.05	8,104,825.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,751,572.80	4,477,597.97
210204	Ажилгүйдлийн даатгал	437,893.38	1,247,953.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,432,900.95	11,232,898.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,617,793.93	27,299,033.75
210301	Гэрэл, цахилгаан	3,311,245.00	13,136,661.05
210302	Түлш, халаалт	3,635,253.20	11,783,347.15
210303	Цэвэр, бохир ус	671,295.73	2,379,025.55
2104	Хангамж, бараа материалын зардал	16,696,322.10	22,759,237.36
210401	Бичиг хэрэг	1,056,600.00	4,933,075.00
210402	Тээвэр, шатахуун	1,782,400.00	2,465,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,575,156.10	4,109,759.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	880,000.00	2,504,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,128,200.00	4,304,236.32
210408	Бараа материал акталсны зардал	8,273,966.00	4,442,967.00
2105	Нормативт зардал	-	2,040,980.00

**Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,040,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	12,224,580.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	12,224,580.00
2107	Томилолт, зочны зардал	9,955,290.00	9,990,000.00
210702	Дотоод албан томилолт	9,955,290.00	9,990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,176,643.60	117,767,183.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,169,079.60	107,134,457.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,980,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,271,180.00	1,253,416.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	542,400.00	353,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	453,200.00
210807	Газрын төлбөр	1,149,984.00	686,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	5,884,010.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,170,121.93	148,541,421.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,084,100.00	6,671,180.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,273,161.93	141,870,241.24
210904	Найдваргүй авлагын алдагдал	2,812,860.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,766,998.82	61,641,714.97
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	17,766,998.82	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	17,766,998.82	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,177,810.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	2,907,810.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,270,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	53,463,904.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	53,463,904.97
<u>3</u>	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН -3=-1--2</u>	(60,358,206.93)	6,251,196,499.50
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,133,400.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,133,400.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	965,309,285.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	965,309,285.78
<u>4</u>	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН -4=-145-225</u>	1,133,400.00	(965,309,285.78)
<u>5</u>	<u>НИЙТ ҮР ДҮН -5=-3+-4</u>	(59,224,806.93)	5,285,887,213.72

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<u>1</u>	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</u>	336,585,733.00	742,426,833.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,561,233.00	19,843,443.63
120	Нийтлэг татварын бус орлого	5,561,233.00	19,843,443.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,557,733.00	19,843,443.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,513,848.00	19,843,443.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,885.00	-
120009	Бусад орлого	3,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,024,500.00	722,583,390.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	324,724,500.00	616,442,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	324,724,500.00	616,442,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,300,000.00	106,140,790.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,300,000.00	17,801,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	88,339,790.00
<u>2</u>	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</u>	323,128,893.00	734,974,033.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	323,128,893.00	734,974,033.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	305,361,894.18	673,412,318.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,863,093.16	423,230,265.21
210101	Үндсэн цалин	205,299,993.16	323,029,778.21
210102	Нэмэгдэл	-	55,682,615.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,829,000.00	26,529,000.00
210104	Урамшуулал	734,100.00	17,988,872.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,308,566.39	55,788,190.00
210201	Тэтгэврийн даатгал	22,068,545.90	36,132,611.84
210202	Тэтгэмжийн даатгал	1,034,268.20	6,794,578.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	851,414.70	3,429,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	212,853.90	857,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,141,483.69	8,574,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,617,793.93	34,534,058.20
210301	Гэрэл, цахилгаан	3,311,245.00	16,014,315.05
210302	Түлш, халаалт	3,635,253.20	16,140,717.60
210303	Цэвэр, бохир ус	671,295.73	2,379,025.55
2104	Хангамж, бараа материалын зардал	9,174,545.10	18,310,297.04
210401	Бичиг хэрэг	1,022,000.00	4,733,450.00
210402	Тээвэр, шатахуун	1,782,400.00	2,465,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,575,156.10	4,109,759.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	880,000.00	2,480,000.00

Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,914,989.00	4,521,888.00
2105	Нормативт зардал	2,389,986.60	2,372,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,389,986.60	2,372,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	9,772,600.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	9,772,600.00
2107	Томилолт, зочны зардал	9,955,290.00	9,990,000.00
210702	Дотоод албан томилолт	9,955,290.00	9,990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,918,519.00	116,428,908.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,910,955.00	109,055,192.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,980,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,271,180.00	1,253,416.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	542,400.00	353,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	453,200.00
210807	Газрын төлбөр	1,149,984.00	686,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	2,625,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,134,100.00	2,985,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,134,100.00	2,985,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,766,998.82	61,561,714.97
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	17,766,998.82	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	17,766,998.82	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,097,810.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	2,907,810.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,190,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	53,463,904.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	53,463,904.97
<u>3</u>	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</u>	13,456,840.00	7,452,800.00
<u>5</u>	<u>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</u>	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	13,456,840.00	7,452,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,456,840.00	7,452,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	13,456,840.00	7,452,800.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	13,456,840.00	7,452,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(13,456,840.00)	(7,452,800.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,280,383,754.15	1,021,463,212.66	(782,641,488.45)	1,519,205,478.36
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,280,383,754.15	1,021,463,212.66	(782,641,488.45)	1,519,205,478.36
Тайлант үеийн үр дүн	105,785,460.00	-	(59,224,806.93)	46,560,653.07
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,386,169,214.15	1,186,666,428.18	(841,866,295.38)	1,730,969,346.95
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	633,541,050.98	633,541,050.98
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,386,169,214.15	1,186,666,428.18	(208,325,244.40)	2,364,510,397.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт	-	(633,541,050.98)	-	(633,541,050.98)
Тайлант үеийн үр дүн	-	-	5,285,887,213.72	5,285,887,213.72
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,386,169,214.15	553,125,377.20	5,077,561,969.32	7,016,856,560.67

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	1	2	3=1-2	4=2/1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	616,442,600.00	590,847,994.45	25,594,605.55	95.8
УРСГАЛ ЗАРДАЛ	616,442,600.00	590,847,994.45	25,594,605.55	95.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	612,234,700.00	586,650,184.45	25,584,515.55	95.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,693,100.00	405,241,393.21	23,451,706.79	94.5
Үндсэн цалин	328,929,000.00	323,029,778.21	5,899,221.79	98.2
Нэмэгдэл	73,235,100.00	55,682,615.00	17,552,485.00	76.0
Унаа хоолны хөнгөлөлт	26,529,000.00	26,529,000.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,586,700.00	53,586,700.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	36,438,800.00	33,931,121.84	2,507,678.16	93.1
Тэтгэмжийн даатгал	4,286,900.00	6,794,578.16	(2,507,678.16)	158.5
ҮОМШӨ-ний даатгал	3,429,400.00	3,429,400.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	857,600.00	857,600.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	8,574,000.00	8,574,000.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,538,300.00	34,534,058.20	1,004,241.80	97.2
Гэрэл, цахилгаан	12,114,800.00	16,014,315.05	(3,899,515.05)	132.2
Түлш, халаалт	21,332,200.00	16,140,717.60	5,191,482.40	75.7
Цэвэр, бохир ус	2,091,300.00	2,379,025.55	(287,725.55)	113.8
Хангамж, бараа материалын зардал	18,314,500.00	18,310,297.04	4,202.96	100.0
Бичиг хэрэг	4,435,900.00	4,733,450.00	(297,550.00)	106.7
Тээвэр, шатахуун	2,465,200.00	2,465,200.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,329,200.00	4,109,759.04	219,440.96	94.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,255,000.00	2,480,000.00	(225,000.00)	110.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,829,200.00	4,521,888.00	307,312.00	93.6
Нормативт зардал	2,400,000.00	2,372,800.00	27,200.00	98.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	2,372,800.00	27,200.00	98.9
Эд хогшил, урсгал засварын зардал	11,749,600.00	11,749,600.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	2,037,000.00	2,037,000.00	-	100.0
Урсгал засвар	9,712,600.00	9,712,600.00	-	100.0
Томилолт, зочны зардал	9,990,000.00	9,990,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	9,990,000.00	9,990,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,910,500.00	47,880,136.00	1,030,364.00	97.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,170,400.00	43,131,420.00	38,980.00	99.9

Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,200,000.00	1,980,000.00	220,000.00	90.0
Даатгалын үйлчилгээ	1,511,000.00	1,253,416.00	257,584.00	83.0
Тээврийн хэрэгслийн татвар	366,100.00	353,400.00	12,700.00	96.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00	22,000.00	50.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	469,000.00	453,200.00	15,800.00	96.6
Газрын төлбөр	1,150,000.00	686,700.00	463,300.00	59.7
Бараа үйлчилгээний бусад зардал	3,052,000.00	2,985,200.00	66,800.00	97.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,052,000.00	2,985,200.00	66,800.00	97.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,207,900.00	4,197,810.00	10,090.00	99.8
Бусад урсгал шилжүүлэг	4,207,900.00	4,197,810.00	10,090.00	99.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,907,900.00	2,907,810.00	90.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	1,290,000.00	10,000.00	99.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	616,442,600.00	590,847,994.45	25,594,605.55	95.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	616,442,600.00	571,004,550.82	45,438,049.18	92.6
Улсын төсвөөс санхүүжих	616,442,600.00	571,004,550.82	45,438,049.18	92.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		19,843,443.63	(19,843,443.63)	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		19,843,443.63	(19,843,443.63)	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	59	55	4	93.2
Удирдах ажилтан	2	1	1	50.0
Гүйцэтгэх ажилтан	39	36	3	92.3
Үйлчлэх ажилтан	18	18	-	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		106,140,790.00
УРСГАЛ ЗАРДАЛ		106,140,790.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		94,214,934.21
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		17,988,872.00
Урамшуулал		17,988,872.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,201,490.00
Тэтгэврийн даатгал		2,201,490.00
Эд хогшил, урсгал засварын зардал		60,000.00
Урсгал засвар		60,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		73,964,572.21
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		71,339,572.21
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		2,625,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,925,855.79
Бусад урсгал шилжүүлэг		3,900,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,900,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,025,855.79
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		8,025,855.79
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		106,140,790.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		106,140,790.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		17,801,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		88,339,790.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Байгалийн түүхийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</b>	Аудитын код:
<b>2020.02.18</b>			САГ-2020/113/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Байгалийн түүхийн музей</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7
1	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн.	14,393.5	Зөвлөмж			Захирал Ахлах нягтлан бодогч	Н.Зоригтбаатар Ш.Дуламсүрэн
2	Хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 350.0 мянган төгрөгөөс, 35.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаад , 84.0 мянган төгрөгийн НДШ тооцоогүй байна. Ажилчдад олгосон 3,900.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс 936.0 мянган төгрөгийн НДШ, 345.1 мянган төгрөгийн ХХОАТ тооцоогүй байна.	1,365.1	Зөвлөмж			Захирал Ахлах нягтлан бодогч	Н.Зоригтбаатар Ш.Дуламсүрэн
<b>Нийт</b>		<b>15,758.6</b>					



